

ДОРНОД АЙМГИЙН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
(ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР)

2023.01.08.

Чойбалсан хот

Д/д	ЗДҮАХ-г тусгагдсан зорилт	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Эх үүсвэр, төсөв (сая.төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт от түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар)	Хувь
НЭГ. "КОВИД-19" ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО									
1.1. "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийг засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг цхэрэгжүүлнэ. Шинэ болон сэргэн тархаж буй халдвараас сэргийлэхэд салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.									
1.1.1.	"Ковид-19" халдварт цар тахлын үед иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих дараах арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.	1	Ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангах, мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	Зохион байгуулалтын ажил	Сургалт сурталчилгаа нөлөөллийн ажил, хувиар	80	82	Хэрлэн сумын 11 багийн 144 хэсгийн ахлагч, улаан загалмайн хорооны 66 сайн дурын ажилтнуудтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан, мэргэжил арга зүйгээр ханган, аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, иргэдэд мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан. Ковид-19 халдварын нэмэлт тунгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх 1 сарын аяны хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд 21 удаа 754 хүнд сургалт зохион байгуулж, 2039 иргэдэд мэдээлэл, сурталчилгааг хүргэсэн. Төр, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит аж ахуй нэгж байгууллагуудад 3 удаа албан тоот хүргүүлж, хуваарийн дагуу давхардсан тоогоор 118 удаа сургалт, нөлөөллийн ажлыг хийж нийт 1447 ажилтан, албан хаагчдад хүрч үйлчилсэн. Коронавируст халдвар /COVID-19/-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр цахим хуудсанд давхардсан тоогоор 915 зөвлөмж байршуулсан, хандалт 45762, давхардсан тоогоор 3127 төрлийн, 18621 ширхэг гарын авлага, зөвлөмжийг иргэдэд түгээсэн. Тайлант онд мэдээлэл,	100
					Мэдээлэл сурталчилгаанд хамрагдсан хүний тоо	29000	30000		

						сургалт, сурталчилгаанд хамрагдсан хүний тоо давхардсан тоогоор 279667 байна. https://www.dornod.moh.gov.mn https://www.facebook.com/dornodemgazar		
	2	Цахим суваг ашиглан КОВИД-19 шинэ болон сэргэн тархаж буй халдвараас сэргийлэхэд салбар дундын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.	Зохион байгуулалтын ажил	Хамтран ажилласан байгууллагын тоо	4	5	“Ковид-19” шинэ болон сэргэн тархаж буй халдвараас сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор анхан шатны 13 сумын өрхийн эрүүл мэнд төв, 3 өрхийн эрүүл мэндийн төв, Цагдаагийн газар, Бүсийн төв Онцгой байдлын газар, ЗДТГ, Хэрлэн сумын ЗДТГ, Боловсрол шинжлэх ухааны газар, сургууль, цэцэрлэгүүдтэй хамтран 69 байгууллагын албаны ёсны цахим хуудас, фэйсбүүк, пэйж хуудсаар дамжуулан сургалт, нөлөөллийг зохион байгуулсан. Тайлант онд хамтран ажилласан байгууллагын тоо 78.	100
1.1.2.”Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн	1	Шинэ болон дахин сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний болон нөөцийн бэлэн байдлыг хангана	Зохион байгуулалтын ажил	Нөөцийн бэлэн байдал хангагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо	19	19	”Ковид-19” халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой эрүүл мэндийн байгууллагууд коронавируст халдварын эмчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн ажиллаж байна. Үүнд: -Вирусын эсрэг эм 8 нэр төрөл 39795 ширхэг	100

санхүүжилтийг нэмэгдүүлнэ.							-Антибиотик эм 8 нэр төрөл, 45213 ширхэг -Дуслын шингэн 8 нэр төрөл 51620 -Амилуулах тусламж үйлчилгээнд шаардлагатай эм бэлдмэл 5 нэр төрөл 343 ширхэг -Эмнэлгийн хэрэгсэл 11 нэр төрөл 68900 ширхэг -Хувийн хамгаалах хэрэгсэл 10 нэр төрөл 302000 ширхэг -ПГУ ялгах 2879, тодорхойлох 1958 , түргэвчилсэн тест шүлс 1890, хамар залгиур 2600 ширхэгийн нөөц бүрдүүлэн эмчилгээ, оношилгоонд хэрэглэж байна.	
	2	Зоонозын өвчин судлалын төв байгуулах саналыг нэгтгэн шийдвэр гаргах түвшинд хүргүүлэх	Зохион байгуулалтын ажил	Авсан арга хэмжээний тоо	0	1	Дорнод аймагт “Зоонозын өвчин судлалын төв” байгуулах үндэслэл, хүсэлтийг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, УИХ-ын гишүүн Ц.Сэргэлэн, Зооноз өвчин судлалын үндэсний төвийн захирал, удирдлагуудад албан бичгээр хүргүүлсэн. Коронавирусийн халдвар зөөвөрлөгдөн орж ирэх эрсдэлийг үнэлэн аймгийн хэмжээнд 5 хилийн боомтын нэвтрэх цэгт тусгаарлах байр, ариутгалын пунктийг түр хугацаагаар байгуулан бэлэн байдлыг ханган ажиллаж байна.	70
	3	Зорилтот бүлгийн иргэдийг “Коронавируст халдвар”-ын дараах нөхөн сэргээх сувилалд хамруулна.	ОНТ	Хамрагдсан иргэдийн тоо	0	1350	Аймгийн Засаг даргын 2022 оны А/47 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд коронавируст халдвар (COVID-19)-ын дараах зорилтот бүлгийн иргэдэд илэрч буй хам шинжийг эмчлэх, уушиг төлжүүлэх, бие махбодийг тэгшитгэх, өвчний үлдэцийг арилгах, амьдралын чанарыг дээшлүүлэх зорилгоор Уламжлалт анагаах ухааны төв, хувийн хэвшлийн “Наран”, “Баянбүрд” мэдрэл, сэргээн засах үүдэн эмнэлэг, 13 сумын Эрүүл мэндийн төвүүдийг түшиглэн сэргээн засах зуны сувиллыг 2022 онд	100

							ажиллуулсан, хамрагдвал зохих зорилтот бүлгийн 1350 иргэнийг 100 хувь хамруулсан бөгөөд сэргээн засах, эмийн эмчилгээ, эрүүл хооллолт, дасгал хөдөлгөөнөөр эрүүлжүүлэн чийрэгжүүлж, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан.	
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН ИНДЕКСИЙН ҮЗҮҮЛЭЛТЭЭРЭЭ АЙМГУУДАА ТЭРГҮҮЛЭГЧ БАЙР СУУРИА ХАДГАЛЖ, ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ, БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.								
2.1. Эрүүл мэндийн салбарт орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.								
2.1.1. “Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ	1	“Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ” БЗДХалдвараас урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах төсөл хэрэгжүүлнэ.	ОНТ	Бэлгийн замын халдварын тохиолдол 10000 хүн амд ноогдох тоо	125	124	Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээ”-ний хүрээнд “Бэлгийн замаар дамжих халдвар болон сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах” төсөл арга хэмжээг 60 сая төгрөгөөр санхүүжүүлэн зорилтот бүлгийн 10000 иргэнийг үзлэгт хамруулахаар төлөвлөж ажилласан ба хамрагдалт 9700 буюу 97 хувь байна. Хэрлэн сумын эрсдэлт бүлгийн 900 гаруй иргэд, ЕБС-ийн 15-18 насны 1460 сурагч, ПТК, ДИС, МСҮТ-ийн 755 оюутан залуус, 10 төрийн байгууллагын 1000 гаруй албан хаагчид, Уул уурхайн 370 ажилчин албан хаагчид, 13 сумын зорилтот бүлгийн 600 иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулж, тэмбүүгийн 21, заг хүйтний 15, трихоминиаз 16, мөөгөнцрийн 30, шээсний сувгийн үрэвсэлт 10 өвчлөлийг илрүүлэн, 100 хувь эмчилгээнд хамруулсан. Хавьтлын илрүүлэлт 85.0 хавьтлын эмчилгээ 80 хувь байна. Бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх 3 төрлийн сэдэвт сургалтыг төрийн болон орон нутгийн өмчит хувийн хэвшлийн 34 байгууллагын ажилтан, албан хаагч, оюутан сурагчид нийт 2585 иргэнд зохион байгуулсан.	100

							Тайлант хугацаанд тэмбүү өвчин өмнөх оны мөн үеэс 36, заг хүйтэн 8 тохиолдлоор буурч, трихоминиаз 161 тохиолдлоор нэмэгдсэн. БЗДХ-ын тохиолдлын тоо 122 болж өмнөх оны мөн үеэс 10.8 промилиор ихэссэн байна.	
2	"Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ" Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах төсөл хэрэгжүүлнэ.	ОНТ	Сүрьеэ өвчний тохиолдол 10000 хүн амд ноогдох тоо	10	9.8	Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах зорилгоор сүрьеэгийн хавьтлын болон эрт илрүүлэг үзлэгт нийт 3134 иргэнийг хамруулж, сэжигтэй 111 иргэнээс сорьц тээвэрлэн сүрьеэгийн 5 шинэ тохиолдлыг илрүүлэн эмчилгээнд хамруулсан. Тайлант онд сүрьеэ өвчний 56 тохиолдол шинээр бүртгэгдсэн нь 10 000 хүн амд 6.7 болж, өмнөх оны мөн үеэс 0.1 промилиор ихэссэн байна. "Сүрьеэ өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх" сэдвээр төрийн 15 байгууллага, аж ахуй нэгж, сургууль, цэцэрлэгийн 500 ажилтан, албан хаагч, хүүхдүүдэд сургалт зохион байгуулж, 1000 ширхэг гарын авлага түгээсэн.	100	
3	"Халдварт өвчинтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээ" Дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлж, томуугийн вакцинд хамруулна.	ОНТ	Дархлаажуулалтын хувь Вакцинд хамрагдсан хүүхдийн тоо	99,4 2160	99.4 2500	Товлолын дархлаажуулалтын хамралт 98,8 хувьтай. Орон нутгийн хөгжлийн сангийн дэмжлэгтэйгээр зорилтот бүлгийн 1-4 насны 2000, сайн дурын дархлаажуулалтад 100, тархвар судлалын заалтаар жирэмсэн, 65 дээш архаг суурь өвчтэй, эрүүл мэндийн байгууллагын ажилтан, 3-12 насны тус тус 11718 иргэн, нийт 13818 хүнийг томуугийн дархлаажуулалтад хамруулж өмнөх оноос 1550 иргэнээр нэмэгдсэн байна	100	
4	Суурь өвчлөлтэй болон зорилтот бүлгийн хүүхдүүдийг зуны сувилалд хамруулах ажлыг үргэлжлүүлнэ.	ОНТ	Сувилалд хамрагдсан хүүхдийн тоо	400	400	Зорилтот бүлгийн болон суурь өвчлөлтэй хүүхдүүдийн зуны сувиллыг 14 суманд ажиллуулах 2 багц бүхий ажлын даалгаврын дагуу 13 суманд сумын эрүүл мэндийн төвийг, Хэрлэн суманд "Их	100	

							нандин групп” ХХК-ыг түшиглэн хоол тэжээлийн хурц болон архаг дутагдлаас үүдэлтэй сульдаа, жингийн алдагдал, цус багадалттай 400 хүүхдүүдийг зуны сувилалд 100 хувь хамруулсан.	
5	Сумын ахмадуудыг өдрийн сувилалд хамруулах	ОНТ	Сувилалд хамрагдсан ахмадын тоо	810	810	Хөдөөгийн 13 сумын Эрүүл мэндийн төвийг болон орон нутаг дахь амралт сувиллын газрыг түшиглэсэн ахмад настны зуны сувилалд нийт 810 ахмад настанг /100хувь/ хамруулж сэргээн засах эмчилгээ, эрүүл хооллолт, эмийн эмчилгээ, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, дасгал хөдөлгөөнөөр эрүүлжүүлсэн. ОНТХ-ийн 27.0 сая төгрөгийн санхүүжилтээр 4 дэх жилдээ хэрэгжсэн сувиллын үр дүнд нийт ахмад настны 87.0 хувьд нь артерын даралт тогтмолжсон, 88.1 хувьд нь нойргүйдэл багассан, 86.0 хувьд нь эрхтэн сиситемийн хавсарсан зовиур болон өвдөлт багассан, сэтгэл зүйн байдал болон хөдөлгөөний идэвхид ахиц гарч эрүүл мэндийн боловсрол дээшилсэн, ахмад настанд чиглэсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн үр дүнтэй байна.	100	
6	Оюутны эрүүл мэндийг дэмжих "Эрүүл оюутан төсөл" хэрэгжүүлнэ	ОНТ	Төслийн хэрэгжилтийн хувиар	80.0	96.0	Аймгийн Засаг даргын 2022 оны А/41 дүгээр захирамжийн дагуу Дорнод Их сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Политехник коллежийн 755 /86.8%/ оюутан залуусыг 6 төрлийн төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж, үзлэгт давхардсан тоогоор 937 өвчлөл /Чих хамар хоолойн өвчлөл 200, нүдний өвчин 199, шүдний өвчлөл 495, бэлгийн замын дамжих халдвартай 21, сүрьеэгийн илрүүлгийн асуумжид гэр бүл болон ойрын хавьтлын өгүүлэмжтэй 12/ илэрсэн ба 65.5 хувийг нь шүдний өвчлөл эзэлж байна.	100	

							Хувийн хэвшлийн Супердент, Family smile, БЭСУ, Гандент шүдний эмнэлгүүдтэй 18.0 сая төгрөгийн гэрээ байгуулан шүдний өвчлөлтэй 1, 2 дугаар дамжааны 200 оюутны амны хөндийг бүрэн эмчлэн эрүүлжүүлж, 702 оюутан залууст халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдахын ач холбогдлын талаарх танхимын сургалт зохион байгуулж, 4 төрлийн сурталчилгааны материалыг 300 хувь хэвлүүлэн түгээж, 45 оюутанг “Оюутан сургагч багш”-аар бэлтгэсэн. Төслийн хэрэгжилт 100 хувь байна.	
7	Аз жаргал төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	ОНТ	Төвөөр үйлчлүүлсэн хүүхдийн тоо	1500	2500	Аймгийн Засаг даргын 2022 оны А/19 дугаар захирамжаар "Аз жаргал төв"-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн 25 сая төгрөгийн санхүүжилттэй төсөл арга хэмжээг баталж, төслийг хэрэгжүүлэхээр “Ашид батжин” ТББ шалгаран ажил гүйцэтгэх гэрээ байгуулан оюутан, залуучууд, өсвөр үеийн сурагчдад сургалт, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Аз жаргал төвөөр тайлант хугацаанд давхардсан тоогоор нийт 7068 хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлж, өмнөх оны мөн үеэс 536 хүүхдээр нэмэгдсэн байна. Шинээр 45 оюутан сургагч багшаар бэлтгэж, үе тэнгийн 262 сургагч багшийг чадавхжуулсан.	100	
8	"Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээ" Эрүүл эмэгтэй төслийг хэрэгжүүлнэ.	ОНТ	Хөтөлбөрийн хэрэгжилт хувиар	70	80	Аймгийн Засаг даргын 2022 оны А/35 дугаар захирамжаар нөхөн үржихүйн 19-40 насны эх барихын ужиг дурдатгалтай эмэгтэйчүүд болон өртөмтгий бүлгийн жирэмсэн 180 эмэгтэйчүүдийг TORCH халдварын шинжилгээнд хамруулах 25 сая төгрөгийн санхүүжилт бүхий төсөл арга хэмжээг батлуулан, шинжилгээнд хамрагдах эхчүүдийн судалгааг гаргасан. “Эрүүл эмэгтэй” төслийн	100	

						худалдан авах ажиллагаа дахин техникийн үзүүлэлт, тоо хэмжээг өөрчлөн тендер зарлаж Илдэн Гүн ХХК шалгарсан ба 2022 оны 12 дугаар сарын 29-нд холбогдох оношлуурыг нийлүүлсэн.	
9	“Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээ”, “Эхчүүдээ хайрлая” төслийг хэрэгжүүлнэ.	ОНТ	Төсөлд хамрагдсан эхчүүдийн тоо	1500	1000	Аймгийн Засаг даргын 2022 оны А/35 дугаар захирамжаар удирдамж, төсөв батлагдан хэрэгжиж, “Эрүүл эмэгтэй” төслийн хүрээнд аймгийн хэмжээнд нөхөн үржихүйн 31-40 насны 1000 эмэгтэйчүүдийг В вирусын эсрэг 3 тунт дархлаажуулалтад бүрэн хамруулсан.	100
10	“Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хүрээнд орон нутагт ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.	ОНТ 11.7	Дэмжлэгт хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо	23	78	“Эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд анхан шатны эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тогтвор суурьшилтай ажиллах, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 39,0 сая төгрөгийг ОНХС-аас 13 сумын эрүүл мэндийн төвийн 78 сувилагчид тус бүр 500 мянган төгрөгийг олгосон.	100
11	“Би сувилагч” төсөл хэрэгжүүлнэ.	ОНТ	Төсөлд оролцогчдын тоо	0	45	Тус онд анх удаа хэрэгжсэн ОНТХ-ийн 70.0 сая төгрөгийн санхүүжилт бүхий “Би сувилагч” төсөлт уралдаан аймгийн Засаг даргын 2022 оны А/222 дугаар захирамжид заагдсан удирдамжийн дагуу 3 үе шаттай зохион байгуулагдаж, шалгарсан 3 сувилагчид орон сууц худалдан авах байрны урьдчилгаанд тус бүр 20 сая төгрөгийн дэмжлэг, бусад 9 сувилагч нарт тус бүр 400.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.	100
12	Элэгний В вирусын халдваргүй нярай төслийг үргэлжлүүлж дархлал тогтоцыг үнэлэх ажлыг зохион байгуулна.	ОНТ	Вакцинд хамрагдсан нярайн тоо	78	80	Монгол Эм Импекс концернтэй гэрээ байгуулж 2022 онд дархлаажуулах 100 хүн тун иммуноглобулиныг хүлээн авсан. Элэгний “В” вирусийн халдвартай эхээс төрсөн 83 нярайг иммуноглобулин(НБИГ)-ээр дархлаажуулж, 20 нярайд дархлал тогтоцыг үнэлсэн ба дархлал тогтоц 93.0 хувьтай байна. Тайлант онд амьд төрөлтийн	100

							тоо 200 тохиолдлоор буурсантай холбоотойгоор үлдэгдэл вакцины хүн тунг 2023 онд халдвартай төрсөн нярайд үргэлжлүүлэн хийнэ.	
13	“Эрчүүдийн эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөр” төсөл хэрэгжүүлэх /эрэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх кабинет байгуулах/	ОНТ	Кабинет байгуулсан эсэх	0	1		Аймгийн Засаг даргын А/96 дугаар захирамжаар “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах” хөтөлбөрийг орон нутгийн төсвөөс 19 сая төгрөгөөр санхүүжүүлж, БОЭТ-ийн сэтгэцийн эрүүл мэндийн тасагт сэтгэл засал, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах кабинетыг тохижуулахад 5.754,000, зорилтот бүлгийн эрэгтэйчүүдэд “Донтох эмгэг түүнээс урьдчилан сэргийлэх, татгалзах” сургалт, бүлгийн болон ганцаарчилсан сэтгэл заслын тусламж үйлчилгээг үзүүлэх, мөн 20-иос доошгүй архины хамааралтай иргэдийг архины хамаарлын шалтгаант сэтгэц, зан үйлийн эмгэгийн оношилгоо, эмчилгээнд хамруулахад 13.246,000 төгрөгийн санхүүжилт тусгагдсан. Энэхүү төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажил гүйцэтгэгчээр Зорилготой амьдрал сургалтын төв НҮТББ шалгарч, Дорнод аймгийн харъяат сайн дураар архинаас татгалзах хүсэлтэй архины хамааралтай иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулан 20 иргэнийг сонгон стандарт эмчилгээнд хамруулсан бөгөөд эдгэрэлт одоогийн байдлар 100 хувь байна. Архи, тамхины хор уршиг түүнээс урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтыг төрийн болон хувийн хэвшлийн аж ахуй нэгж, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, оюутнууд, Хэрлэн сумын 11 багийн ажил эрхэлдэггүй иргэд нийт 3600 иргэнд зохион байгуулж, “Архи тамхины хор уршиг”, “Амьдрах ухаан”, “Эрүүл зөв амьдрал”	70

							сэдэвт гарын авлагыг 1500 ширхэгийг түгээсэн байна.	
14	Халдварт бус өвчнөөс сэргийлэх арга хэмжээний хүрээнд харшлаас сэргийлэх ажил зохион байгуулна.	ОНТ	Суурь судалгааг эхлүүлэх	0	1		Аймгийн Засаг даргын 2022 оны А/22 захирамжаар “Харшлаас сэргийлэх” төсөл арга хэмжээнд 7.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, хүн амын дундах арьс харшлын өвчлөлд түүвэр судалгаа хийх, харшлын өвчлөлд нөлөөлж байгаа хүчин зүйлийг тандан судлах, иргэдэд сургалт сурталчилгаа нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Тус төслөөр “Derma med” арьс, харшил, гоо заслын хувийн хэвшлийн үүдэн эмнэлэгтэй хамтран ургамлын тоосонцорын харшилтай, харшлын сорилд хамрагдаж байгаагүй 200 иргэнийг арьс хатгах сорилд хамруулж, 50.8 хувь хогийн ургамал /агь, шарилж/, 20,5 хувь нь модлог ургамал /арц, бургас/, 18,4 хувь нь үет ургамал /зүлэг өвс, хөх тариа/, 8,9 хувь нь тоосны хачиг /тоосны хачиг, агуулахын тоос/, 1 хувь нь амьтан /муур/, 1.3 хувь нь хүнсний зүйл /газрын самар/-ээс тус тус харшилтай байна. Төслийн хүрээнд ургамлын харшлыг бууруулахад хувь хүн, айл өрх, албан байгууллагын оролцоог нэмэгдүүлэн тэдгээрт чиглэсэн зөвлөмж боловсруулсан.	100
15	Эрүүл мэндийг дэмжих байгууллага шалгаруулах болзолт уралдааныг зохион байгуулна	ОНТ	Дэмжигч байгууллагын тоо	0	5		Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/472 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/22, А/559 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Эрүүл мэндийг дэмжигч байгууллага шалгаруулах орон нутгийн дэд комиссын гишүүдэд шалгуулахаар хүсэлтээ өгсөн 7 байгууллагуудад үнэлгээ хийсэн. Үнэлгээний дүнд Хэрлэн сумын 9 дүгээр цэцэрлэг 1 дүгээр зэрэг, Цагаан Овоо сумын цэцэрлэг 3 дугаар зэрэг, Булган сумын цэцэрлэг 3 дугаар зэрэг,	100

						Дашбалбар сумын эрүүл мэндийн төв 1 дүгээр зэрэг Баяндун сумын эрүүл мэндийн төв 2 зэрэг, Соёлын төв 3 дугаар зэргийн гэрчилгээний болзлыг тус тус хангаж, мөнгөн урамшуулал, батламжийг гардууллаа. Нийт 7 байгууллагаас 6 тэнцэж, Эрүүл мэндийг дэмжигч байгууллагад шинээр 3, зэрэг ахиулсан 3 шалгарсан. Аймгийн хэмжээнд “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” нийт 26 боллоо.	
16	Зүрх судасны өвчлөлөөс сэргийлэх МОНПЕН санаачилгыг нутагшуулна	ОНТ	Төсөлд хамрагдсан иргэдийн тоо	0	8000	Аймгийн Засаг даргын 2022 оны А/22 дугаар захирамжаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр ХБӨ/Зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх Монпен төслийн хүрээнд 18-аас дээш насны иргэдийг артерийн гипертензи, чихрийн шижин өвчнийг эрт илрүүлэг үзлэгт хамруулахад шаардагдах оношлуурт зарцуулагдах санхүүжилтэд ОНХС-аас 42.0 сая төгрөгийн дэмжлэг бүхий тендерийг зохион байгуулж, анхан шатны эрүүл мэндийн байгууллага тус бүрт сахар тест 420 ширхэг холестерин тест 420 ширхэг оношлуурыг хүлээлгэн өгч, нөөцийг бүрдүүлэн эрт илрүүлэг үзлэгийн зохион байгуулан ажилласан. Уг арга хэмжээний хүрээнд зорилтот насны иргэдийн 56,9 хувь буюу 10921 хамруулж, шинээр артерийн гипертензи 119, чихрийн шижингийн 25 өвчлөл илрүүлж хяналтандаа аваад байна.	100
17	“Сургууль цэцэрлэгийн эмч ба Эрүүл мэнд” төсөл хэрэгжүүлнэ	ОНТ	Төсөлд хамрагдсан сургууль, цэцэрлэгийн тоо	0	62	Ерөнхий боловсролын 26 сургуульд 11, 36 цэцэрлэгт 10 нэр төрлийн 47.6 сая төгрөгийн багаж, тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчээр Сүвэн-Уул ХХК шалгарч, гэрээний хугацаанд багаж тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.	100

<p>2.1.2. Эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ.</p>	<p>1</p>	<p>Эрүүл мэндийн байгууллагуудын дэд бүтцийг сайжруулан стандарт чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх орчин бүрдүүлнэ</p>	<p>ОНХС</p>	<p>Шинээр баригдсан эрүүл мэндийн барилга, байгууламжийн тоо Засвар хийсэн эрүүл мэндийн байгууллагын тоо</p>	<p>0 3</p>	<p>3 4</p>	<p>- Хүүхдийн 200 ортой 9.5 тэрбум төгрөгийн өртөг бүхий шинэ эмнэлгийн барилгын ажил 2021 оны 08 сард эхэлсэн бөгөөд гүйцэтгэгчээр Ихбазар констракшн ажиллаж байна. Хүүхдийн эмнэлгийн барилгын инженерийн шугам сүлжээ, дотоод заслын 2.3 тэрбум төгрөгийн ажлын худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж гүйцэтгэгчээр Ихбазар констракшн шалгарсан. Барилгын гүйцэтгэл 2021 онд 2.1 тэрбум төгрөгөөр А блокын 4 давхар хүртлэх карказын ажил, 2022 онд 676.0 сая төгрөгөөр В блокын суурийн ажил, А блокын дээврийн караказын ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.</p> <p>-Улсын төсвийн 1.5 тэрбумын хөрөнгө оруулалтаар Баянтүмэн сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажил 2022 оны 5 дугаар сард эхэлж, 2022 оны 9 сард ашиглалтад орсон.</p> <p>- Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 450.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Хэрлэн сумын алслагдсан 2, 3 дугаар багийн нутаг дэвсгэрт баригдах ӨЭМТөвийн салбар шинээр барих барилгын ажлын гүйцэтгэгчээр Дорнын танан өргөө ХХК шалгарч барилга 2022 оны 10 сард ашиглалтад орсон.</p> <p>- Улсын төсвийн 1.6 тэрбум, орон нутгийн төсвийн 199.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Нийгмийн эрүүл мэндийн төв”-ийн шинэ барилга 2022 оны 11 дүгээр сард ашиглалтад орлоо.</p> <p>- Аймгийн ОНТ, ОНХСангийн 291.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд хэрэгжих Булган сумын эхийн амрах байрны барилгын ажлын гүйцэтгэгчээр Донж өргөө ХХК шалгарч барилгын ажил эхэлсэн бөгөөд 2023 онд ашиглалтад орно.</p>	<p>70</p>
---	----------	---	-------------	---	----------------	----------------	--	-----------

							-Аймгийн ОНТ, ОНХСангийн 442.8 сая төгрөгөөр 5 сумын эрүүл мэндийн төвд засвар хийгдэхээр төлөвлөгдсөнөөс Чойбалсан, Хөлөнбуйр, Баяндун, Чулуунхороот сумын ЭМТөвүүдийн засварын ажил бүрэн дуусч ашиглалтад хүлээн авсан. Сэргэлэн СЭМТ-ийн ариун цэврийн байгууламжийн засварын ажлын худалдан авах ажиллагаа 4 удаа зохион байгуулагдаж оролцогч санал ирүүлээгүй шалтгаанаар амжилтгүй болсон.	
	2	Эрүүл мэндийн байгууллагуудыг нэн шаардлагатай орчин үеийн тоног төхөөрөмжөөр үе шаттай хангана	ОНХС,ОНТ	Тоног төхөөрөмжөөр хангагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо	13	6	Эрүүл мэндийн болон боловсролын 66 байгууллагуудад тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл нийлүүлэхээр аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас 321.3 сая төгрөг батлагдсан. 12 сарын байдлаар 66 байгууллагад 219.0 сая төгрөгийн эмнэлгийн болон сургалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нийлүүлэгдсэн бөгөөд БОЭТөвд нийлүүлэгдэх “Сэргээн засах болон эмнэлгийн тоног төхөөрөмж” төслийн 73.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх гүйцэтгэгчээс ирүүлсэн хүсэлтийн дагуу гэрээний сунгалтыг хийгээд байна.	100
2.1.3. Хөдөөгийн хүн амд төрөлжсөн тусламж үйлчилгээг хүргэх “Хөдөлгөөнт эмнэлэг” ажиллуулна.	1	Нийгмийн цогц явуулын үйлчилгээ /эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, соёл, ахуй үйлчилгээ/	ОНТ	Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо	10182	10000	Алслагдсан нутгийн болон отор нүүдэл хийж байгаа малчдад хүрч үйлчлэх “Нийгмийн цогц явуулын үйлчилгээ”-нд нийт 10766 иргэн хамрагдсаны 7238 иргэн дотор, эмэгтэйчүүд, хэт авиа, хүүхэд, нүд, шүд, чих хамар хоолойн төрөлжсөн мэргэжлийн эмчид үзүүлсэн нь үзлэгт хамрагдсан иргэд өнгөрсөн оныхоос 81 хувиар өссөн байна.	100
2.1.4. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн аргыг эрүүл	1	Эрүүл мэндийн байгууллагуудыг гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэнд үе шаттай шилжүүлнэ.	УТ, ЭМДС	Санхүүжилтийг шилжүүлсэн эсэх	2	15	Эрүүл мэндийн байгууллагуудыг гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэнд 100 хувь шилжүүлсэн.	100

Мэндийн байгууллагуудад нэвтрүүлнэ.								
2.1.5. Шаардлагатай сум, багт төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд эмийн сангийн үйлчилгээг хүргэнэ.	1	Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд аймаг сумын төвийн алслагдсан багуудад эмийн сан ажиллуулна	ОНТ	Алслагдсан багт байршилтай эмийн сангийн тоо	3	4	Аймгийн төвөөс алслагдсан Хэрлэн сумын 1 дүгээр багийн иргэдэд эм зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх Арвижих тан 2 дугаар зэрэглэлийн эмийн санг ажиллуулахаар зөвшөөрөл олгосон. Алслагдсан багийн 1, 2, 8 дугаар багийн иргэдэд эм зүйн тусламж үзүүлэх 3 эмийн сангийн байрны түрээсийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс олгосон.	100
2.1.6. Эрүүл мэндийн салбарын ажилтан, албан хаагчдын нийгмийн хамгааллыг дэмжин, нэн шаардлагатай мэргэжлээр эмнэлгийн мэргэжилтнийг бэлтгэн чадавхижуулна	1	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлтэд суурилсан нэн шаардлагатай эмч мэргэжилтнээр үе шаттай хангана.	Зохион байгуулалтын арга хэмжээ	Шинээр бэлтгэгдсэн эмч мэргэжилтний тоо	21	16	Тайлангийн хугацаанд буюу эмнэлгийн мэргэжилтний 2021-2022 оны хичээлийн жилд төгсөлтийн дараах үндсэн мэргэшил олгох сургалтад хамрагдаж төгссөн 11 эмч, мэргэжилтэн, 2022-2023 оны хичээлийн жилд 26 эмч, мэргэжилтэн суралцаж, нийт 37 эмч, эмнэлгин мэргэжилтнийг төрийн сангийн санхүүжилтээр суралцуулсан байна.	100
ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ								97.0

ТАНИЛЦСАН:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА /Ч.ОЮУНАА/
ХЯНАСАН:
МЭРГЭЖИЛТЭН /Б.ГАНТУЯА/
НЭГТГЭСЭН:
МЭРГЭЖИЛТЭН /Д.САРАНГЭРЭЛ/